

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СТАНДАРТ ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Авто тээврийн хэрэгслийн даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	✓ Тийм			Үгүй		
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	<input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	А, В, С, D ангиллын тээврийн хэрэгсэл					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Зам тээврийн осол 2. Байгалийн үзэгдэл 3. Ахуйн осол 4. Гал 5. Мал амьтны нөлөө 6. Жолоо шилжүүлэх 7. Шилний хохирол 8. Бусдын санаандгүй үйлдэл 9. Өөрийн санаандгүй үйлдэл					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1,0%					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Хохирлын шалтгааныг тогтоолгоогүй, эсхүл нөхөн тогтоох боломжгүй болсон;
2. Даатгалын зүйлд хохирол учруулах орчин, нөхцөлийг санаатай эсвэл болгоомжгүйгээр бүрдүүлсэн;
3. Даатгуулагч, жолооч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс даатгалын зүйлд хохирол учруулсан;
4. Даатгуулагч, жолооч нь худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
5. Тээврийн хэрэгслийг согтуугаар эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоодсон, Замын хөдөлгөөний дүрэмд заасан хурдны хязгаарыг хэтрүүлсэн болох нь мэргэжлийн эрх бүхий байгууллага эсхүл гэрээний 3.5-д заасан шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон, гэмт хэргийн зорилгоор хууль бусаар ашиглах үед үүссэн хохирол;
6. Даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байх үед эсвэл даатгалын гэрээнд заагдаагүй, тухайн багцад хамаарагдаагүй эрсдэлийн улмаас учирсан хохирол;
7. Тээврийн хэрэгслийн цахилгааны гэмтэл, тээврийн хэрэгсэлд засвар хийх, тээврийн хэрэгслийг зориулалтын бус аргаар халаах, асаах зэрэгтэй холбоотойгоор үүссэн галын хохирол;
8. Тээврийн хэрэгслийн мотор, дугуй зэргээс буюу түүний өөрийн эд ангиас (гаднын аливаа нөлөөлөл, шалтгаангүй) үүссэн галын хохирол;
9. Тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан үедээ автомашин жолоодсон, эрүүл мэндийн хувьд жолоо барих шаардлага хангахгүй этгээдээр жолоо барих үед учирсан хохирол;
10. Тээврийн хэрэгслийг жолооны сургалтын зориулалтаар ашиглах, ан ав хөөх, уралдаан тэмцээнд оролцуулах /бартаат зам/, тээврийн хэрэгслийн хүч, туулах чадварыг турших, зэргээс учирсан хохирол;
11. Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн бол тэр хэмжээгээр;
12. Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйн улмаас автомашинд гарсан ердийн эвдрэл, автомашины ердийн элэгдэл хорогдол, үйлдвэрийн гологдол, механик эвдрэл гэмтлээс учирсан хохирол;
13. Ой мод, гуу, жалга, уул нуруу бүхий газраар зорчсон, эсхүл замгүй газраар зорчсоноос учирсан хохирол;
14. Тээврийн хэрэгслийг явган хүний зам болон тээврийн хэрэгслийн зорчих хэсэгт байрлуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл зогсоход зориулагдаагүй, бусдын хөдөлгөөнд саад учруулах байдлаар байрлуулснаас учирсан хохирол;
15. Засвар үйлчилгээ, машины нөхцөл байдлыг сайжруулах болон тэдгээрээс шалтгаалан үүссэн хохирол;
16. Үйлдвэрээс тээврийн хэрэгсэлд суурилуулаагүй, шинээр нэмж суурилуулсан эд анги болон тээврийн хэрэгслийн компьютерын программ хангамжид учирсан хохирол, мөн тэдгээрээс үүссэн хохирол;
17. Дайн, цөмийн болон цацраг идэвхт бодис, эдгээртэй холбоотой үйл ажиллагаа, дотоодын үймээн самуун, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, нийтийн эмх замбараагүй байдал зэргийн улмаас үүдсэн хохирол;
18. Гэрээний 5.11-д заасан хугацааг хэтрүүлсэн, 5.12-д заасан үүргээ биелүүлээгүй болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;